



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт такси үйлчилгээ эрхлэгч компаниудын жолооч нарт зориулсан англи хэлний анхан шатны мэдлэг олгох радио сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Сургалтын төсөв болох 300.000 /Гурван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Эвент хариуцсан мэргэжилтэн /Б.Оюунзул/, Мэдээлэл сурталчилгааны төвийн менежер /Б.Анар/ нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 20.12 оны // сарын 11-ны өдрийн 77. тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Такси үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан англи хэлний зайн сургалт зохион байгуулах удирдамж

Зорилго:

Жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, тэдний дахин ирэх хүсэл сонирхлыг төрүүлэх гол зүйл нь үйлчилгээ байдаг. Энэ утгаараа аливаа газрын аялал жуулчлалын хөгжлийг үйлчилгээний чанар тодорхойлдог. Үйлчилгээний чанар нь сайтар бэлтгэгдсэн боловсон хүчинээс шууд хамааралтай. Улаанбаатар хотын аялал жуулчлалын үйлчилгээнд гардаг гол дутагдлууд нь жуулчид хотын аяллаас зайлсхийх нэг шалтгаан болж байна. 2012 онд судалгаанд хамрагдсан 2133 жуулчны 105 нь таксины жолоочыг мөнгө залилдаг, тоолуургүй, тасалбар өгдөггүй, автомашин нь бохир, тусгай зогсоолд зогсдоггүй, хэт хурдан бөгөөд дүрэм зөрчин давхидааг, хамгаалалтын бүсгүй, англи хэл огт мэддэггүй, үйлчилгээний соёлгүй, бүдүүлэг харьцдаг гэж хариулсан байна.

Аялал жуулчлал хөгжсөн олон оронд такси үйлчилгээг тодорхой шаардлагуудыг хангасан жолооч нар бүхий мэргэжлийн компаниуд явуулдаг. Учир нь таксины жолооч нар дийлэнх тохиолдолд жуулчны хөтөч тайлбарлагч, орчуулагч, газарчийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Иймд хотын аялалд гадаад хэл, харилцааны ур чадвар эзэмшсэн жолооч бүхий такси үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор уг зайндын сургалтыг зохион байгуулж байна.

Сургалтын агуулга:

Таксины үйлчилгээ эрхэлж байгаа жолооч нарт зориулсан англи хэлний анхан шатны сургалтыг зайн хэлбэрээр зохион байгуулна. Зайн сургалтыг харилцан яриа хэлбэрээр FM радио 100.1-д бичүүлж, хичээлийг давталтайгаар FM радио 100.1, Авто радио FM 96.3-аар нийтэд цацна. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд сургалтыг хөтлөн явуулах юм.


Хамрах хүрээ:

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа такси үйлчилгээ эрхэлдэг компаниудын жолоочид болон иргэд хамрагдана.

Зохион байгуулагчид:

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, FM радио 100.1, Авто радио FM 96.3

Хүрэх үр дүн, хугацаа: 2013 оны 11-12 дугаар сар. Энэхүү зайн сургалтыг зохион байгуулснаар таксины жолооч нар англи хэлний анхан шатны харилцан яриаг эзэмшинэ. “Найрсаг Улаанбаатар” аяныг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлнэ.



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 20.Зоны //.. сарын 11-ны өдрийн
Ч.Утоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Такси үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан англи хэлний
зайн сургалт зохион байгуулах төсөв**

№	Зардлын зүйл	Toо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ/төгрөг/
1.	Зайн сургалтын радиогийн бичлэг хийх	8	37.500	300.000
	Нийт			300.000